

**Б.БААСАНЖАВЫН НАМТАР, УЛС ТӨРИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТУХАЙД
(1930-1936 он)**

С.Даш

Монголын залуучуудын холбооны түүх, судалгааны ажилтан

Банзаржавын Баасанжав 1906 онд Дөрвөдийн баруун аймгийн Мянгад дайчин гүний хошуу, одоогийн Ховд аймгийн Мянгад сумын Үүргэсний бууц хэмээх нутагт төржээ.

1923 он хүртэл эцэг эхийн гар дээр өсч хүмүүжиж байв. 1923-1927 онд Мянгад хошууны тамгын газрын танхим болон тухайн үеийн Чандмань уулын аймгийн төв Улаангомьн бага сургуульд суралцан төгсчээ. 1927-1929 онд Улаангомд болон Хөхий уулын хошууны бага сургуульд багшаар ажиллажээ. Тэрбээр 1930 онд Улаангомьн намын үүрт МАХН-ын гишүүнээр элсчээ. 1929-1931 оны хоёрдугаар сар хүртэл Мянгад хошууны ХЗЭ-ийн товчлох хорооны зохиолын хэлтсийн эрхлэгч, Ховд аймгийн нам, эвлэлийн хорооны хэлтсийн эрхлэгч, намын хорооны нарийн бичгийн даргаар, 1931 оны 2-р сараас 1932 оны 3-р сар хүртэл МАХН-ын Төв Хорооны зааварлагчаар, 1932 оны гуравдугаар сарын 22-оос 1936 оны аравдугаар сар хүртэл Ховд аймгийн намын хорооны нарийн бичгийн даргаар, 1936 оны аравдугаар сарын 7-оос 1940 оны хоёрдугаар сарын 23 хүртэл МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж байсны гадна 1937 оны аравдугаар сараас 1939 оны есдүгээр сар хүртэл МҮЭ-ийн Төв Зөвлөлийн даргаар хавсран ажиллаж байв.

Б.Баасанжав 1940 оны хоёрдугаар сарын 23-нд улс төрийн хэрэгт баривчлагдаж, мөрдөгдөж байгаад мөн оны есдүгээр сарын 29-нд уушигны өвчнөөр нас барсан байна.

Б.Баасанжавыг БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дэргэдэх Улс төрийн хилс хэрэг цагаатгах комиссын 1957 оны долдугаар сарын 10-ний өдрийн нэгдүгээр тогтоолоор уг хэрэгт нь холбогдолгүй болгон цагаатгажээ. Түүнийг улс төрийн талаар буруутгах ямарч үндэс шалтгаан байгаагүй байна. Б.Баасанжавын намтар судлалд түүний МАХН-д гишүүнээр элссэн эхэн үеийн буюу 1930-1936 оны үеийн улс төрийн оролцоо, үйл ажиллагаа ихээхэн анхаарал татдаг.

Энд тэмдэглэн өгүүлэхэд тэрбээр 17 настайдаа МХЗЭ-д гишүүнээр элсэж, 1923 онд Мянгад хошууны ХЗЭ-ийн үүрийн даргаар анх сонгогдож, 1929-1930 онд Мянгад хошууны Залуучуудын эвлэлийн товчлох хорооны зохиолын хэлтсийн эрхлэгч, нарийн бичгийн даргаар сонгогдон хөдөө нутгийн малчин залуучуудыг Ардын хувьсгал, МАХН-ын үзэл санаагаар хүмүүжүүлэхэд хүчин зүтгэж, улмаар 1930 онд МАХН-ын гишүүнд элссэн түүхтэй ажээ.

Б.Баасанжавын намтар, улс төрийн үйл ажиллагааны эхэн үеийг судлахад 1931 оны хоёрдугаар сараас 1932 оны 3 сар хүртэл МАХН-ын Төв Хороонд зааварлагчаар томилогдон ажилласан үе ихээхэн чухал ач холбогдолтой юм гэж бид үзэж байна. Энэ үеийн МАХН-ын удирдлагад “зүүний” алдаатай бодлого, үйл ажиллагаа зонхилж байсныг түүх өгүүлдэг. Гэсэн ч намын дотоод амьдрал, үйл ажиллагааны зарчимд хэм хэмжээ, нам засгийн дотоод гадаад бодлого зэргийг өргөн хүрээнд ойлгож, улс төрийн мэдлэг боловсролоо дээшлүүлж, намын ажлын туршлага зээмшиж, улс төр, үзэл суртлын хатуужилтай жинхэнэ намын ажилтан болж төлөвшихөд нь намын төв аппаратын үйл ажиллагаа үлэмж их нөлөөлсөн байна.

МАХН-ын Төв Хороонд зааварлагчаар ажилласан хугацаандаа орон нутгийн намын байгууллагын ажил байдлыг шалгаж зааварлахын зэрэгцээ, удирдах ажлын зохих дадлага туршлагатай, өсөх ирээдүйтэй ажилтан болохоо харуулжээ. (Х.Магсаржав. “Намын амьдрал” сэтгүүл. 1989 он. №6. 77-78-р тал)

Б.Баасанжавын МАХН-ын удирдлаганд ажиллаж байсан үе нь хувьсгалын ардчилсан шатны зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө тэмцэж байсан үе байсан юм.

IV. ТҮҮХЭН ХҮН СУДЛАЛ, НАМТАР СУДЛАЛЫН АСУУДЛУУД

“Зүүний” нугалаа завхрал газар авч, түүнд ард олон дургүйцэн, өмнө талын аймгуудаар дүрвэн нүүж, нийт 14 аймгийг хамарсан лам, ардын бослого гарч, эл бослого Ховд аймгийг ч хамарсан түүхэн хариуцлагатай хүнд үе 1932 оны 3 сард МАХН-ын Төв Хороо Б.Баасанжавыг Ховд аймгийн намын хорооны даргаар ажиллуулах шийдвэр гаргасан болохыг академич Ч.Болдбаатар онцлон өгүүлжээ. (Ж.Болдбаатар. “Мянгад нутгийн нэрт хөвгүүн. Монголын төр, нийгмийн зүтгэлтэн Банзаржавын Баасанжав”. УБ. 2006. 15-р тал)

Тэрбээр юуны өмнө Улаангом, Төгсбуянтын хүрээнд гарсан лам, ардын бослогын үлдэгдлийг дарж намжаан, хязгаар нутгийг тохинуулж, амар жимэр амьдралын нөхцлийг бий болгох талаар чадах бүхнээ хийсэн байна. (Дээр дурдсан ном. 15-р тал)

Хязгаар нутгийн олон ястнаас бүрдсэн Ховд аймагт “зүүний” нугалааны үед хилийн чанад дахь мулла, лам нарын ятгалгаар ардууд их хэмжээгээр дүрвэж, тэдний санаа сэтгэл алдагдахад хүрсэн байлаа.

Ийм үед дүрвэгсдийг нутагт нь ирүүлэх, ирсэн хүмүүст мал, орон сууц олгох, нутгийн захиргаа байгуулах, тэдний дотор нам, засгийн бодлогыг сурталчлах зэргээр ард олныг төвхнүүлж, энх амгалан аж төрөх нөхцлийг бүрдүүлэхэд Б.Баасанжав намын хорооны даргын хувьд чухал үүрэг гүйцэтгэжээ. Мөн “зүүний” алдаа завхралыг засах, шинэ эргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд намын байгууллага, гишүүдийн хүчийг зөв зохион байгуулж удирдсан байна.

Б.Баасанжавыг Ховд аймгийн намын хорооны даргаар ажиллаж байсан үед Баруун хязгаарын байдал ноцтой хурцдаж, хасагийн дээрэмчид нутгийн гүнд удаа дараа цөмрөн орж, улс хоршоолол, ардуудын эд хөрөнгийг дээрэмдэж, хүний амь бүрэлгэх болсон. Ийм нөхцөл байдалд Ховд аймгийн яам, намын хорооны удирдлага Баасанжав нар нөхцөл байдлыг нарийн шинжилж, төр засагтаа өргөн мэдүүлж, нэгдсэн хүчээр дээрэмчдийг бут цохиж, хил хязгаартаа амгалан тайван байдал тогтоож чадсан билээ. Энэ тухай МАХН-ын IX их хурал дээр Б.Баасанжав хэлсэн үгэндээ, тус аймагт хасагийн дээрэмчид ирж, ардын хөрөнгө хогшлыг талан дээрэмдэх, хүн ардыг хэрцгийгээр зовоож алах зэргээр маш хүнд байдал учруулсныг дурдаад, тэдгээр дээрэмчдийг цохиж, нутгийн ард түмний 60 мянган малыг авчирч эздэд нь олгосон явдлыг ард олон баярлан сайшааж, биширч байна. Үүний үрээр манай аймаг сүүлийн үед улс төрийн талаар баттай амгалан тайван болсон гэжээ. (МАХН-ын IX их хурал. Дэлгэрэнгүй тайлан. УБ.1984. 408 дахь тал)

1935 оны долдугаар сард Ховд аймгийн намын хорооны нарийн бичгийн дарга Б.Баасанжавыг Коминтерний VII их хуралд төлөөлөгчөөр томилж явуулжээ. Тус их хурал дээр олон орны коммунист, ажилчны хөдөлгөөний нэрт зүтгэлтэн, гарамгай хувьсгалч, интернационалистуудын тавьсан илтгэл, хэлсэн үгийг сонсож, дайн фашизмын аюулын эсрэг олон улсын ажилчин ангийн эв нэгдлийг бэхжүүлэхийн төлөө тэмцэлд Коминтерний зүгээс тавих зорилттой танилцсан зэрэг нь Б.Баасанжавын улс төрийн мэдлэг, оюуны өсөлт, практик үйл ажиллагаанд асар их нөлөөлжээ. Б.Баасанжав хожим нь, “Дэлхий дахины коммунистуудын энэ их хуралд би хайрт намынхаа итгэл найдварыг хүлээж, намаа төлөөлөн оролцсон минь урьд өмнө ийм сайхан хурлыг үзээгүй, зөвхөн практик ажилд зүтгэж явсан миний зоригийг бадруулж, идэвхийг өрнүүлсэн маш их, хэзээ ч мартагдашгүй аз жаргалтай нэг зүйлийн их сургууль боллоо” гэж дурсан бичжээ.

МАХН-ын Төв Хороо Коминтерний VII их хуралд оролцсон төлөөлөгчдийн илтгэлийг 1935 оны есдүгээр сард сонсоод гаргасан тогтоолдоо: VII их хурлаас гаргасан бодлогууд нь хувьсгалын ялалтыг урагш давшуулж, японы түрэмгийлэгчдийн эсрэг ардын нэгдсэн хүчээр эсэргүүцэж, тус орны тусгаар тогтносон байдлыг бэхжүүлж, эдийн засаг, соёлыг хөгжүүлэх хэрэгт туйлын их ач холбогдолтой зүйл мөн (НТА. Х.1. т.5. хн.101. хуудас 101) гэж тэмдэглэжээ.

Б.Баасанжав намаас итгэж хүлээлгэсэн үүрэг даалгаврыг сайн биелүүлж байсан учир намын хорооны хэлтсийн эрхлэгч, аймгийн намын хорооны даргаас Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга, тэргүүлэгч гишүүн хүртэл дэвшин ажиллажээ гэж доктор

IV. ТҮҮХЭН ХҮН СУДЛАЛ, НАМТАР СУДЛАЛЫН АСУУДЛУУД

Х.Магсаржав 1989 оны 4-р сарын 5-ны өдөр 30, 40-өөд онд хилсээр хэлмэгдсэн нам, төрийн зарим зүтгэлтний намын гишүүний асуудлаар боловсруулах түүхчдийн хуралд зориулан Б.Баасанжавын тухай гаргасан танилцуулагад онцлон өгүүлжээ. (Банзаржавын Баасанжав. Баримт бичгийн эмхтгэл. УБ. 2009. 176-р тал)

МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Нийгмийн Ухааны Институтын 30, 40-өөд онд хилсээр хэлмэгдсэн нам, төрийн зарим зүтгэлтний намын гишүүний асуудлаар санал боловсруулах түүхчдийн группийн 1989 оны дөрөвдүгээр сарын 16-ний өдрийн хурлаар хэлэлцэн зөвшөөрсөн Банзаржавын Баасанжавын тухай товч тодорхойлолтод:

“Б.Баасанжав практик үйл ажиллагааныхаа явцад намын ажлын дадлага туршлага олж, ажил үйлсээр үнэлэгдэн, намын удирдах тушаалд дэвшсэн нам ардын хувьсгалын үйл хэрэг, хөдөлмөрчин олон түмний эрх ашигт үнэнч, намын удирдах ажилтан юм” гэж онцлон дүгнэжээ. (Мөн тэнд. 192-р тал)

Монголын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Б.Баасанжавын намтар, улс төрийн үйл ажиллагааны эхэн үеийг товч хөндөн өгүүлэхэд ийм байна.